



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

### Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Амар даатгал” ХХК-ийн “Байгууллагын хариуцлагын даатгал”-ын бүтээгдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Олон нийтийн өмнө хүлээх хариуцлагын даатгал”-ын бүтээгдэхүүнийг хоёрдугаар хавсралтын дагуу тус тус бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Амар даатгал” ХХК /Т.Батзул/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 1-д заасан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Амар даатгал” ХХК /Т.Батзул/-д анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



F:\ajil 2020\hural\huulbar unen\togtool.docx

151800000031

Санхүүгийн зохицуулах хорооны  
2020 оны 4 сарын 29 өдрийн  
32-р тогтоолын нэгдүгээр хавсралт

Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Амар даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Байгууллагын хариуцлагын даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Хариуцлагын даатгал
4.	Даатгалын зүйл	Байгууллагын үйл ажиллагааны улмаас гуравдагч этгээдэд учруулсан эдийн болон эдийн бус хохирлын өмнө хүлээх хариуцлага
5.	Даатгалын эрсдэл	Байгууллагын эзэмшил, өмчлөлийн газар нутаг дээр зорчиж буй гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд байгууллагын үйл ажиллагаанаас үүдэн хохирол учрах аливаа үйл явдал болон түүний ажиллагсдын болгоомжгүй, хайхрамжгүй үйлдэл, эс үйлдэл
6.	Даатгалын гэрээний хугацаа	1 жил хүртэл
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	12 бүлэг, 210 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн ЗТ-19/07-005 тоот шийдвэр
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Д.Уранцэцэг
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Бизнес хөгжлийн газрын захирал Т.Тэлмэн, Үйл ажиллагааны газрын захирал Я.Энхбаяр, Хуулийн зөвлөх Г.Энхцэцэг, Даатгалын менежер Э.Хулангаа



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Амар даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Олон нийтийн өмнө хүлээх хариуцлага
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Хариуцлагын даатгал
4.	Даатгалын зүйл	Даатгуулагчийн ажил үйлчилгээ явуулж байгаа эзэмшил газар буюу ашиглаж байгаа газарт түүний санаатай бус үйл ажиллагааны улмаас гуравдагч этгээдийн амь нас эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирсан хохирлын хариуцлага.
5.	Даатгалын эрсдэл	<ul style="list-style-type: none"><li>• Гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэндэд учруулж болох хохирол;</li><li>• Гуравдагч этгээдийн эд хөрөнгөнд учруулж болох хохирол.</li></ul>
6.	Даатгалын гэрээний хугацаа	1 жил хүртэл
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	12 бүлэг, 210 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн ЗТ-19/07-005 тоот шийдвэр
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Д.Уранцэцэг
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Бизнес хөгжлийн газрын захирал Т.Тэлмэн, Үйл ажиллагааны газрын захирал Я.Энхбаяр, Хуулийн зөвлөх Г.Энхцэцэг, Даатгалын менежер Э.Хулангаа